



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2024/03/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Мандалговь хот 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Ихбаяр Утас: 70593113 Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn</p> <p>Аудитор: Т.Оюун-Эрдэнэ Утас: 70593113 Цахим хаяг: Oyunerdenet@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ-УС ОНӨААТҮГ- ЫН ЗАХИРАЛ О.БАРХҮҮ ТАНАА

2024-03-25 № 109

танай _____ -ны № _____ -т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад санхүүгийн тайлангийн аудит хийлгээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан дахь 218.2 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй 57.8 сая төгрөгийн ажил гүйлгээ хийсэн зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/, 20 дугаар зүйлийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/, 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг ишийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1-т /Худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд илжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээнэ/, мөн иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Дундговь-Ус ОНӨААТҮГ-т Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Биг могул коул энд энержи” ХХК-аас аймаг болон сумын Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу нийгмийн хариуцлагын хүрээнд хандивласан 2000 тонн нүүрсийг орлого авч бүртгэлд тусгаагүй зарцуулсныг аудитын явцад залруулсан. Уг санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Мөн нүүрс худалдан авах тендер болон тендерийн баримт бичигт захиалагчийн тодорхойлсон багцын тоо хэмжээг 1097 тонн, 1 тонн нүүрсний үнийг 25.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн гэрээг байгуулж, худалдан авалтыг хийсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т /«Хамгийн сайн» үнэлэгдсэн тендер болон тендерийн баримт бичигт захиалагчийн тодорхойлсон худалдааны болон техникийн шаардлага нь худалдан авах гэрээний үндсэн нөхцөл болно/ 42 дугаар зүйлийн 42.1.2-т /Захиалагч энэ хуулийн 27, 28, 29 дүгээр зүйлд заасан журмыг зөрчиж гэрээ байгуулсан/ заасныг зөрчсөн байна. Тус зөрчил нь гэмт хэргийн шинжтэй байх эрсдэлтэй тул хуулийн байгууллагад шалгуулах саналыг Монгол Улсын ерөнхий аудиторт хүргүүлсэн. Уг үйл явдлыг гол асуудал гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын захирал нь аудитын явцад аудитын багт мэдэгдэлгүй албан бус ажлаар эзгүй байсан нь аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авахад, аудитын дүнг баталгаажуулахад хүндрэлтэй байдал үүсгэсэн.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	26,728,773.02	44,572,702.03
1.1.02	Дансны авлага	188,699,968.79	269,613,544.95
1.1.06	Бараа материал	12,084,199,537.38	13,264,604,387.10
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	12,299,628,279.19	13,578,790,634.08
1.2.01	Үндсэн хөрөнгө	34,020,248,087.78	33,402,064,177.02
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	34,020,248,087.78	33,402,064,177.02
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	46,319,876,366.97	46,980,854,811.10
2.1.1.01	Дансны өглөг	3,192,929.64	229,685,830.50
2.1.1.03	Татварын өр	23,622,461.79	133,895,450.66
2.1.1.04	НДШ - ийн өглөг	0.00	51,691,894.94
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	26,815,391.43	415,273,176.10
2.1.2.01	Урт хугацаат зээл	13,558,578,529.33	15,075,963,944.05
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	13,558,578,529.33	15,075,963,944.05
2.2	Өр төлбөрийн нийт дүн	13,585,393,920.76	15,491,237,120.15
2.3.02	- хувийн	23,883,924,070.10	24,321,432,579.22
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	15,449,157,774.34	15,449,157,774.34
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	-3,835,415,924.32	-3,835,415,924.32
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-2,763,183,473.91	-4,445,556,738.29
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-1,682,373,264.38
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-2,763,183,473.91	-2,763,183,473.91
2.3.11	Эздийн өмчийн дүн	32,734,482,446.21	31,489,617,690.95
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	46,319,876,366.97	46,980,854,811.10

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,319,146,464.52	1,701,057,702.63
02	Борлуулалтын өртөг	2,262,632,237.48	3,688,908,615.26
03	Нийт ашиг(алдагдал)	-943,485,772.96	-1,987,850,912.63
08	Бусад орлого	45,432,745.95	533,412,155.88
08.1	Орлогын дүн	45,432,745.95	533,412,155.88
10	Ерөнхий ба удирдлагын зардал	162,183,061.77	200,351,545.06
12.1	Зардлын дүн	162,183,061.77	200,351,545.06
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	-27,582,962.57
17.1	Олз, гарзын дүн	0.00	-27,582,962.57
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-1,060,236,088.78	-1,682,373,264.38
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-1,060,236,088.78	-1,682,373,264.38
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1,060,236,088.78	-1,682,373,264.38

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	22,675,573,908.92	15,449,157,774.34	-3,835,415,924.32	-1,702,947,385.13	32,586,368,373.81
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00

03	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-1,060,236,088.78	-1,060,236,088.78
05	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
06	Өмчид гарсан өөрчлөлт	1,208,350,161.18	0.00	0.00	0.00	1,208,350,161.18
07	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
09	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	23,883,924,070.10	15,449,157,774.34	-3,835,415,924.32	-2,763,183,473.91	32,734,482,446.21
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-1,682,373,264.38	-1,682,373,264.38
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	437,508,509.12	0.00	0.00	0.00	437,508,509.12
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	24,321,432,579.22	15,449,157,774.34	-3,835,415,924.32	-4,445,556,738.29	31,489,617,690.95

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,646,575,668.88	2,294,616,406.29
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,579,977,480.88	1,839,731,176.29
1.1.6	Бусад мөнгөн орлого	66,598,188.00	454,885,230.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,765,202,156.64	2,276,772,477.28
1.2.1	Ажиллагчдад төлсөн	468,956,238.98	755,282,558.88
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	75,160,032.70	70,787,796.95
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	533,011,647.00	206,441,434.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	177,309,512.94	297,163,729.37
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	261,118,880.00	593,508,003.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	102,192,671.37	86,654,584.19
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	147,453,173.65	266,934,370.89
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-118,626,487.76	17,843,929.01
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-118,626,487.76	17,843,929.01
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	145,355,260.78	26,728,773.02

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2023 оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Борлуулалтын орлого	2,377,690,000.00	2,234,469,858.51	143,220,141.49	94.0

2	ББӨ	4,101,715,400.00	3,688,908,615.26	412,806,784.74	89.9
3	Нийт ашиг	-1,724,025,400.00	-1,454,438,756.75	-269,586,643.25	84.4
4	Ерөнхий удирдлагын зардал	206,363,500.00	227,934,507.63	-21,571,007.63	110.5
5	Цалингийн сан	1,153,265,900.00	815,157,391.54	338,108,508.46	70.7

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 681,422.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 169,779.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 231,349.6 мянган төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлж, 280,292.7 мянган төгрөгийн 2 зөрчлийг хуулийн байгууллагад шалгуулахаар хүргүүлсэн.

Залруулсан алдаа:

Аудитын явцад 169,779.8 мянган төгрөгийн дараах алдаануудыг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн. Үүнд:

1. 8,433.5 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг тавилгын дансанд бүртгэсэн;
2. Авлагын тодруулга тайлангийн эцсийн үлдэгдлийг 25,964.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
3. Хандиваар ирсэн 130,000.0 мянган төгрөгийн нүүрсийг орлого авч, бүртгэл тайланд тусгаагүй, зарцуулсан;
4. Хувь хүнд өгөх 5,381.6 мянган төгрөгийн өр төлбөрийг тайлагнаагүй. Эдгээр нь үнэлгээ ба хуваарилалт, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Залруулаагүй алдаа:

Аудитаар нийт 511,642.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 231,349.6 мянган төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлж, 280,292.7 мянган төгрөгийн 2 зөрчлийг хуулийн байгууллагад шалгуулахаар хүргүүлсэн.

Үүнээс Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу завсрын аудитаар өгсөн албан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан учир байгууллагын удирдлагад сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн.

3.1 Албан шаардлага

3.1.1 Ашигт ажиллагааны түвшин алдагдалтай, татварын байгууллагад өртэй байхад ТУЗ-ийн гишүүдэд 8,400.0 мянган төгрөгийн урамшуулал олгож төсвийг хэмнэлтгүй зарцуулсан.

Энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д */Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох/*, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т */Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/* заасныг;

3.1.2 Батлагдсан орон тооноос хэтрүүлэн гэрээгээр зөвлөн туслах нягтлан бодогчийг ажиллуулж 3,600.0 мянган төгрөгийг олгосон.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т */Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох/*, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т */Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох/* заасныг;

3.1.3 Хагас жилийн хөрөнгийн тооллогын комиссын бүрэлдэхүүнд эд хариуцагчийг оруулж томилсон.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-т */Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна/* заасныг тус тус зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1.4 Албан хаагчдын хувийн тээврийн хэрэгслийг ашиглан ажил үйлчилгээ гүйцэтгүүлж 1,113.2 мянган төгрөгийн шатахуун зарцуулахдаа гэрээ байгуулаагүй, гүйцэтгэлийг дүгнээгүй, тогтмол дүнгээр олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т */Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д */Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/*, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т */дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/*, заасныг;

3.1.5 Санхүүгийн тайлан дахь 218,236.4 мянган төгрөгийн авлагыг харилцагчидтай тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д */дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/*, мөн хуулийн 20.2.6-д */эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/* заасныг тус тус зөрчсөн байна.

3.2 Хариуцлага тооцуулах албан шаардлага

3.2.1 Санхүүгийн тайлангийн аудитаар “Сөрөг” санал дүгнэлт авсан, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагуудыг заасан хугацаанд хэрэгжүүлээгүй, биелэлтийг ирүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т */Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ/* заасныг зөрчсөн байна.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Компьютер, тоног төхөөрөмжийг тавилгын дансанд бүртгэсэн.	1	8,433.5			1	8,433.5	1	8,433.5				
Авлагын тодруулга тайлангийн эцсийн үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан.	1	25,964.8			1	25,964.8	1	25,964.8				
Хандиваар ирсэн нүүрсийг орлого авч, бүртгэл тайланд тусгаагүй, зарцуулсан	1	130,000.0	1	130,000.0			1	130,000.0				
Хувь хүнд өгөх өр төлбөрийг тайлагнаагүй.	1	5,381.6	1	5,381.6			1	5,381.6				
Дүн	4	169,779.8	2	135,381.6	2	34,398.3	4	169,779.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Батлагдсан орон тооноос хэтрүүлэн зөвлөн туслах нягтлан бодогч ажиллуулсан.	1	3,600.0			1	3,600.0						
Албан хаагчдын хувийн тээврийн хэрэгслийг ашиглан ажил үйлчилгээ гүйцэтгүүлж шатахуун зарцуулахдаа гэрээ байгуулаагүй, гүйцэтгэлийг дүгнээгүй, тогтмол дүнгээр олгосон	1	1,113.2			1	1,113.2						
Санхүүгийн тайлан дахь авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй.	1	218,236.4				218,236.4						

Дундговь-Ус ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Тендерт шалгараагүй иргэн, хуулийн этгээдээс гэрээ байгууллаагүй, пүүний бичиггүй нүүрс худалдан авсан	1	57,832.7								1	57,832.7
Дүн	4	280,782.3			3	222,949.6				1	57,832.7

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хариуцлага тооцуулах албан шаардлага	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн	-	-										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Ашигт ажиллагааны түвшин алдагдалтай, татварын байгууллагад өглөгтэй байхад ИТХ-ын шийдвэргүйгээр ТУЗ-ын гишүүдэд урамшуулал олгосон.	1	8,400.0			1	8,400.0						
Хагас жилийн хөрөнгийн тооллогын комисст нярвыг оруулж томилсон.	1	-			1	-						
Нүүрс худалдан авах тендерийн баримт бичигт захиалагчийн тодорхойлсон багцийн тоо хэмжээг 1097 тонн, 1 тонн нүүрсний үнийг 25.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн гэрээг байгуулж, худалдан авалтыг хийсэн. Гэрээний дагуу нийлүүлэгдсэн нүүрс нь чулуу ихтэй, чанарын шаардлага хангаагүй, хаягдал их хэмжээгээр үүссэн.	1	222,460.0							1	222,460.0		
Санхүүгийн тайлангийн аудитаар “Сөрөг” санал дүгнэлт авсан, өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлагуудыг заасан хугацаанд хэрэгжүүлээгүй, биелэлтийг ирүүлээгүй.	1	-									1	-
Дүн	4	230,860.0			2	8,400.0			1	222,460.0	1	-
Нийт дүн	4	230,860.0			2	8,400.0			1	222,460.0	1	-